



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/13/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он	Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.	Error! Bookmark not defined.
4.2 Албан шаардлага.	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагван сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.03.25 - № 89

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020914

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/ мянган төгрөгөөр/
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		814,403.0	1,104,306.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	283,604.0	449,653.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	189,482.8	215,694.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	341,316.2	438,959.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,750,531.8	6,014,061.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	5,750,531.8	6,014,061.1
39200	Биет хөрөнгө		5,680,186.1	5,934,070.9
39300	Биет бус хөрөнгө	13	70,345.8	79,990.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		6,564,934.9	7,118,367.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		4,386.0	517.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	4,386.0	517.0
41300	Өглөг	17а, 17б	4,386.0	517.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,560,548.9	7,117,850.6
51	Засгийн газрын хувь оролцоо		6,560,548.9	7,117,850.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,497,653.6	1,497,653.6
51200	Хуримтлагдсан үр дүн		4,379,935.2	4,937,236.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		682,960.1	682,960.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		6,564,934.9	7,118,367.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/ мянган төгрөгөөр/
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,469,590.2	3,764,132.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		29,808.0	114,869.9
110	Орлогын албан татвар		23,064.4	17,445.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		23,064.4	17,445.8
113	Хөрөнгийн албан татвар		930.0	42,224.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		5,813.6	55,199.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	345,183.1	836,634.8
120	Нийтлэг татварын бус орлого		345,183.1	836,634.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,094,599.1	2,812,627.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,272,652.6	3,182,050.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,272,652.6	3,182,050.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,490,247.6	3,077,947.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,503,048.6	1,578,233.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		188,290.8	203,698.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		263,550.3	251,992.5
2104	Хангамж, бараа материалын зардал		85,742.9	83,277.2

2105	Нормативт зардал		64,056.7	271,967.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		19,544.2	35,923.8
2107	Томилолт, зочны зардал		6,778.0	8,658.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		19,446.0	28,216.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		339,790.1	615,979.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		782,405.0	104,103.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		196,937.6	582,081.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		49,963.7	24,419.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		146,973.9	557,661.8

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,414,478.3	0.0	6,414,478.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-903.4	0.0	-903.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,413,575.0	0.0	6,413,575.0
9	Тайлант үеийн үр дүн	146,973.9	0.0	146,973.9
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,560,548.9	0.0	6,560,548.9
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,560,548.9	0.0	6,560,548.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-360.0	0.0	-360.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,560,188.9	0.0	6,560,188.9
19	Тайлант үеийн үр дүн	557,661.8	0.0	557,661.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,117,850.6	0.0	7,117,850.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,236,168.5	2,997,274.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	29,808.0	114,869.9
110	Орлогын албан татвар	23,064.4	17,445.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	23,064.4	17,445.8
113	Хөрөнгийн албан татвар	930.0	42,224.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,813.6	55,199.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,655.3	5,146.0
1181	Газрын төлбөр	2,158.3	10,237.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	39,816.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	111,761.3	158,163.8

120	Нийтлэг татварын бус орлого	111,761.3	158,163.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,094,599.1	2,724,240.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,995,135.8	2,656,058.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,995,135.8	2,656,058.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,214,671.4	2,551,634.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,503,033.2	1,577,696.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,290.8	203,733.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	263,550.3	251,992.5
2104	Хангамж, бараа материалын зардал	78,764.8	82,882.1
2105	Нормативт зардал	44,586.6	157,409.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,934.2	51,703.6
2107	Томилолт, зочны зардал	6,778.0	8,658.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,446.0	28,489.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,287.5	189,069.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	780,464.4	104,424.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	241,032.7	341,215.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	113,761.8	175,166.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	113,761.8	175,166.8
2200	Дотоод эх үүсвэрээр	113,761.8	175,166.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-113,761.8	-175,166.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	127,270.9	166,049.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	156,333.1	283,604.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	283,604.0	449,653.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,940,758.3	2,522,915.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,482,900.9	2,405,846.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,432,686.2	2,355,672.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,515,877.7	1,505,301.7
210101	Үндсэн цалин	1,084,923.6	1,080,754.0
210102	Нэмэгдэл	303,077.0	297,916.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,885.0	3,867.0
210104	Урамшуулал	123,992.1	122,764.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,991.8	196,110.4
210201	Тэтгэврийн даатгал	139,451.5	137,828.8
210202	Тэтгэмжийн даатгал	15,404.1	15,095.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,275.4	12,021.7
210204	Ажилгүйдлийн даатгал	2,912.6	2,829.0
210205	Эрүүл мэндийн даатгал	28,948.2	28,335.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,180.5	250,097.0
210301	Гэрэл, цахилгаан	12,832.4	12,755.5
210302	Түлш, халаалт	233,628.3	233,621.7
210303	Цэвэр, бохир ус	3,719.8	3,719.8

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	69,600.2	69,241.9
210401	Бичиг хэрэг	6,229.8	6,222.5
210402	Тээвэр, шатахуун	34,434.1	34,406.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,362.6	5,347.3
210404	Ном, хэвлэл	988.0	889.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,623.0	2,420.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,962.7	19,956.5
2105	Нормативт зардал	76,449.9	74,265.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,513.8	38,510.0
210502	Хоол, хүнс	35,007.5	32,838.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,928.6	2,917.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	129,054.2	99,332.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	53,117.5	53,092.4
210602	Тавилга	10 097,90	10,084.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,854.6	7,215.0
210604	Урсгал засвар	48,984.2	28,940.4
2107	Томилолт, зочны зардал	8,964.1	8,658.0
210702	Дотоод албан томилолт	8,964.1	8,658.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,932.0	5,876.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,312.8	1,312.1
210803	Даатгалын үйлчилгээ	602.7	602.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	251.7	250.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	171.0	121.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,253.5	2,253.5
210807	Газрын төлбөр	206.3	202.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,134.0	1,134.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	175,635.8	146,788.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	170,925.3	142,100.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,710.5	4,687.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,214.7	50,174.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,214.7	50,174.2
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	17,718.0	17,717.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,025.7	30,985.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,471.0	1,471.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	332,781.8	117,069.0
223001	Бусад хөрөнгө	332,781.8	117,069.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,940,758.3	2,653,820.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,745,780.7	1,735,212.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,578,523.8	1,567,955.5
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	167,256.9	167,256.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	825 872,90	780,559.7
320001	Орон нутгийн төсвөөс	825,872.9	780,559.7
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-

33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,909.6	6,510.0
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,909.6	6,510.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	346,195.1	131,538.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,195.9	67,333.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,983.6	64,204.9
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	261,015.6	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	261,003.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	391,908.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		316,587.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		316,587.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		272,905.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		75,668.8
210102	Нэмэгдэл		66,018.2
210104	Урамшуулал		9,650.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		7,623.0
210201	Тэтгэврийн даатгал		5,190.5
210202	Тэтгэмжийн даатгал		610.7
210203	ҮОМШӨ-ний даатгал		474.8
210204	Ажилгүйдлийн даатгал		133.75
210205	Эрүүл мэндийн даатгал		1,213.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,895.5
210301	Гэрэл, цахилгаан		1,895.5
2104	Хангамж, бараа материалын зардал		21,482.8
210401	Бичиг хэрэг		2,645.0
210402	Тээвэр, шатахуун		5,695.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		645.3
210404	Ном, хэвлэл		737,340.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		539.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,584.0
2105	Нормативт зардал		83,143.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		76,288.2
210502	Хоол, хүнс		6,855.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,626.1
210604	Урсгал засвар		2 626,10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		22,612.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		22,612.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		57,852.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		57,852.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		24,700.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		18,981.7

213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		18,981.7
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		319,782.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		319,782.9
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		33,271.7
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		96,514.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		21,368.7
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		168,628.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		3,195.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,195.8

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Дэлгэрхангай сум нь эрхэм зорилгоо “Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах, иргэдэд төрийн чанартай үйлчилгээг хүргэж тасралтгүй сурталчлах алба байхад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдсэн байна. Хяналт, шалгалтын дүнд өгөгдсөн зөвлөмж байхгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,182,050.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 31,820.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 22,274.3 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 553,432.8 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	283,604.0	449,653.1	166,049.1
Авлага	189,482.8	215,694.2	26,211.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	341,316.2	438,959.3	97,643.1

**Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Үндсэн хөрөнгө	5,750,531.8	6,014,061.0	263,529.3
Нийт хөрөнгө	6,564,934.8	7,118,367.6	553,432.8
Өр төлбөр	4,386.0	517.0	(3,869.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,560,548.8	7,117,850.6	557,301.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,564,934.8	7,118,367.6	553,432.8

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 166,049.1 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлыг 332,781.8 мянган төгрөгөөр төсөвлөсөн боловч цар тахлын улмаас хил хаагдаж бараа бүтээгдэхүүний үнэ өссөн, зарим үйл ажиллагааг хязгаарлаж байснаас цаг хугацааны хувьд хойшлогдсон зэргээс шалтгаалан 117,069.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь нөлөөлсөн.

Авлагын дансны үлдэгдэл 26,211.3 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас цар тахлын эмчилгээний 94,488.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 97,643.1 мянган төгрөгөөр өссөн нь цар тахлын эм тариа, вакцин, вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах хамгаалах хэрэгслийг Эрүүл мэндийн төвд хүлээн авч бүртгэж тайлагнасанатай холбоотой.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 58,097.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 386,227.0 мянган төгрөг, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж орлого авсан 89,800.6 мянган төгрөг, шилжүүлэн авсан 16,663.3 мянган төгрөг, бусад хөрөнгөнд 24,128.3 мянган төгрөг, нийт 574,917.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, 180,533.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж болон шилжүүлэн данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,117,850.6 мянган төгрөг болж 557,301.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Дэлгэрхангай сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 35 дугаар тогтоолоор Дэлгэрхангай сум тайлант онд 132,260.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 141,495.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 106.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого				
Үйл ажиллагааны орлого	14,000.0	16,415.8	2,415.8	117.3
Хөрөнгө борлуулсны орлого	-	1,030.0	1,030.0	1,030.00
Бүүны албан татвар	850.0	1,062.0	212.0	124.9
Малд ноогдуулах албан татвар	64,000.0	41,162.5	(22,837.5)	64.3
Улсын тэмдэгтийн хураамж	2,500.0	3,236.5	736.5	129.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	350.0	687.8	337.8	196.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,500.0	1,221.6	(2,278.4)	34.9
Газрын төлбөр	2,060.0	10,237.7	8,177.7	497
Ангийн нөөцийн орлого	23,300.0	39,816.0	16,516.0	170.9
Дүн	110,560.0	114,869.9	4,309.9	-
Татварын бус орлого				
Хүүгийн орлого	18,200.0	23,107.1	4,907.1	127.0
Торгуулийн орлого	3,500.0	3,518.5	18.5	100.5
Дүн	21,700.0	26,625.6	4,925.6	-
Нийт дүн	132,260.0	141,495.5	9,235.5	

Эх сурвалж: Дэлгэрхангай сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хувь хүний орлогын албан татварын орлого 2,415.8 мянган төгрөгөөр давсан нь арьс шир, ноосны урамшууллаас суутгасан татварыг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Газрын төлбөр 8,177.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь суманд газрын даамлаар мэргэжлийн хүн хариуцан ажиллаж уул уурхайн компанийн газарт ногдуулалт хийсэнтэй холбоотой байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг авах журмыг тусгайлан сумын онцлогт тохируулан батлаагүйгээс тус орлого 2,278.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Малд ноогдуулах албан татвар 22,837.5 мянган төгрөгөөр тасарсан нь Дундговь аймагт байгалийн гамшиг болон ган зуд болсонтой холбогдуулан засгийн газрын хуралдааны тэмдэглэлд тулгуурлан Дэлгэрхангай сумын ИТХ-ийн хуралдаанаар малд ноогдуулах тоо толгойн татварыг 50 хувь хөнгөлсөн тогтоол гаргасан. Тогтоол гаргаснаас хойш орон нутгийн орлогын малд ноогдох татварыг 64,000.0 мянган төгрөгийг 52,000.0 мянган төгрөгөөр тогтоох тооцоолол байсан боловч ИТХ-ийн жилийн эцэст нэг хуралдаан зарласнаар төсөв тодотгох боломж гараагүй болно.

Хадгаламжийн хүүгийн орлого 4,907.1 мянган төгрөгөөр даван биелсэн нь тус сумын иргэдийн банкны хадгаламжийн хэмжээ өссөнтэй холбоотой бөгөөд жил бүрийн хадгаламжийн хүүгийн орлого төлөвлөгөөнөөсөө даван биелсэн байна.

Ангийн нөөцийн орлого жилийн төлөвлөгөөнөөс 16,516.0 мянган төгрөгөөр даван биелсэн нь даван биелсэн нь ангийн зөвшөөрөл төлөвлөгөөнөөс илүү олгогдсонтой холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дэлгэрхангай сумын ИТХ-ын 2020 он 11 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,764,916.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,764,916.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Дэлгэрхангай сумын ИТХ-ын 2021 оны 24 болон 35 тогтоолоор батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 175,841.6 мянган төгрөгөөр нэмж тодотгон 2,940,758.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2,940,758.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,482,900.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 332,781.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 125,075.6 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 1,745,780.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 825,872.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22,909.6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 85,179.5 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 261,015.6 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,735,212.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 780,559.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 6,510.0 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 131,538.3 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 261,003.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 67,333.4 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 20,137.5 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлого 64,204.8 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 26,221.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь Сум хөгжүүлэх сангийн хүүгийн орлого бөгөөд тайлант онд шинээр нэмж зээл гаргаагүй, зээлдэгч нар зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу зээлээ төлсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,522,915.2 мянган төгрөг буюу 85.7 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний бусад зардал 77,054.1 мянган төгрөг, хөрөнгийн зардал 215,712.8 мянган төгрөг, урсгал зардлаас 40.6 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлийн гүйлгээ хийгдээгүйгээс 125,712.8 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Улсын төсвийн санхүүжилтээс дутуу зарцуулсан 10,568.3 мянган төгрөгийг улсын төсөвт, орон нутгийн төсвийн санхүүжилтээс дутуу зарцуулсан 21,069.8 мянган төгрөгийг тус сумын орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 33,271.7 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 96,514.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21,368.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 168,628.5 мянган төгрөг, нийт 319,782.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсний зардалд 75,668.8 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 7,623.0 мянга, байр ашиглалттай холбоотой зардалд 1,895.5 мянга, хангамж бараа материалын зардалд 21,482.8 мянга, нормативт зардалд 83,143.7 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 2,626.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 22,612.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 57,852.8 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 24,700.0 мянга, нийт 297,605.3 мянган төгрөгийг зарцуулж, 18,981.7 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 3,195.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 79,999.2 мянган төгрөгийн, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 36,000.0 мянган төгрөгийн, Улсын онцгой комиссын №297 тоот тогтоолоор олгосон 85,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслүүд нэмэгдсэн байна. Уг хөрөнгүүдийн худалдан авах ажиллагааг дээд шатны байгууллага зохион байгуулан худалдан авч шилжүүлсэн байна.

Ковид-19 цар тахал тархсантай холбоотой тайлант онд тусламж хандив, төсвийн өөрийн хөрөнгөөр нийт 289,169.4 мянган төгрөгөөр эм боох материал, хамгаалах хувцас, хэрэгсэл, эмийн багц, ковидын тест, дархлаажуулалтын вакцин худалдан авч, 239,007.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй эм нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү дүнгээр нэхэмжилсэн 180 ширхэг эмийн үнэ 2,197.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан. алдааг аудитын явцад залруулсан.

3.8 Аудитын гол асуудал

Дэлгэрхангай сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хэвийн бус ажил гүйлгээ гараагүй.

Харин удирдлага зохион байгуулалтын хувьд доголдолтой, дотоод хяналт хангалтгүй аудитор өндөр шүүмжлэлтэй хандаж буй эрсдэлтэй асуудал нь аймгийн Эрүүл мэндийн газраас нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн орлогыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зарцуулалтад хяналт тавиагүй асуудал байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийт 3,625,030.7 мянган төгрөгийн 155 мэдээллээс 147 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн, хугацаанд нь байршуулж, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм” зөрчсөн зөрчлүүдийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газар, Тусгай зориулалтын сангууд, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийсэн. Завсрын аудитаар нийт 89,007.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 26,531.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 134.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 58,042.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 4,300.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Дээрх зөрчлийг арилгаж, хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 12,747.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	5	2,791.3	5	2,791.3			100
Албан шаардлага	11	10,216.0	11	10,216.0			100
Зөвлөмж	2		2				
Нийт	18	13,007.3	18	13,007.3			100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын шатахуун, хүнсний материал, Эрүүл мэндийн төвийн эмийн зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 8 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 159,610.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 53,636.0 мянган төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 297.5 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 99,527.4 мянган төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага, 6,150.0 мянган төгрөгийн 6 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 66.4 хувийг залруулагдаагүй, 33.6 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал ихэнх буюу 33,258.3 мянга буюу 20.8 хувь нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай, 126,217.8 мянган төгрөг буюу 79.2 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

4.1 Албан шаардлага

1. Хувь хүнээс авах 5,855.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.
2. Авлагын үлдэгдэл 80.9 мянган төгрөгийг тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээ аваагүй

Шийдвэрлэсэн нь: Дээрх 5,936.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгаль хамгаалах сангийн өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/ 20.2.6. /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Өглөгүүдийг судлан хууль журмын дагуу арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 7 дугаар сарын 25 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
3	ОНХС	1	30,000.0					1	30,000.0		
4	Соёлын төв	2	5,554.9					1	3,704.9	1	1,850.0
5	БХС	2	4,380.9					1	80.9	1	4,300.0
6	МХС	1	5,855.5					1	5,855.5		
7	дүн	6	45,791.3					4	39,641.3	2	6,150.0
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ИТХ	1	35.4	1	35.4						
2	ЗДТГ	2	47,100.4	1	523.7				46,576.7		
3	ЭМТ	5	4,309.0	2	2,220.7	1	163.3	1	1,925.0	1	
4	ЕБС	7	62,240.5	3	50,856.1			3	11,384.4	1	
5	Цэцэрлэг	1	134.2			1	134.2				
	дүн	16	113,819.5	7	53,635.9	2	297.5	4	59,886.1	2	-
	Нийт зөрчлийн дүн	22	159,610.8	7	53,635.9	2	297.5	8	99,527.4	4	6,150.0